

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



PLITONIT эпоксид зуурмагийн үлдэгдлийг арилгах целлюлоз хөөсөнцөр



Целлюлоз хөөсөнцөр нь керамик, чулуу, шил, металл, мод зэрэг гөлгөр гадаргуугаас шинэхэн эпоксидын өнгөр, зуурмагийн илүүдлийг арилгах, түүнчлэн шаваасны эцсийн шатанд хавтан хоорондын залгаасны шаваасыг гөлгөр болгох зориулалттай.

Целлюлозоор хийгдсэн хөөсөнцөр нь зөөлөн ба бат бэх материал бөгөөд элэгдэлд тэсвэртэй, зуурмагтай харьцах үед эвдэрдэггүй, үйрдэггүй, залгаасны үеийг бөглөдөггүй. Том сүвтэй бүтэцтэй тул хөөсөнцөр нь чийгийг төгс шингээж, бохирдолтыг сайн цэвэрлэдэг.

Хөөсөнцрийн хэмжээс 170x100x47 мм.

PLITONIT Целлюлоз хөөсөнцөртэй ажиллахын давуу тал, ашиг тус

- Элэгдэлд тэсвэртэй, зуурмагтай харьцах үед эвдэрдэггүй, залгаасны үеийг бөглөдөггүй
- Зөөлөн учир хавтанг зурдаггүй бөгөөд залгаасны үеийн зуурмагийг угааж гаргадаггүй.
- Тээвэрлэлтийн явцад богино хугацаанд турш бол хөлдөөхийг зөвшөөрдөг.
- Хадгалах хугацааг хязгаарладаггүй

Ажлын дараалал

Эпоксид зуурмагаар залгаасыг дүүргэсний дараа шууд цэвэрлэгээг хийж эхэлж болно. Зуурмагийг түрхсэний дараа нэн даруй гадаргууг нойтон хөөсөнцрөөр зайлан угааж, дараа нь хавтангийн гадаргуугаас зуурмагийг бүрэн арилгах хүртэл сайтар базсан алчуураар шахаж арчина.

Анхааруулга!

Сайн үр дүнд хүрэхийн тулд бүлээн усаар угаагаад, хөөсөнцөр сайн угаагдаж зайлагдахын тулд усыг илүү олон удаа сольж, хэрэглэхийг зөвлөж байна.

Орц, найрлага

100% целлюлоз

Хадгалах нөхцөл

Зөвлөж буй хадгалах температур нь +5°C хэмээс +30°C хэм хүртэл байна. Тээвэрлэлтийн явцад богино хугацаанд хөлдөөхийг зөвшөөрнө. Хадгалах хугацааг хязгаарладаггүй.

Логистикийн мэдээлэл

Хувийн бар-код	4607013047846
Бүлгийн бар-код	14607013047843
Хайрцаг дахь хөөсөнцрийн тоо	18 ширхэг
Багц дахь хөөсөнцрийн тоо	1260 ширхэг